



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1/52

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/141 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жилийн хүрээнд 2023 оны татвар төлөгчдийн өдрүүдийг угтан татвар төлөгч иргэд, аж ахуйн нэгжийн ажлын байранд сургалт, мэдээлэл хийх, хариуцлагатай татвар төлөгчдийг сурталчлах, "Бид хариуцлагатай татвар төлөгч" аяныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Ганчимэг (Татварын улсын байцаагч)

Гишүүд: П.Амгаланбаатар (Чавчирын Өлгий хоршоо)

З.Түвшигтөр (ХХЭрхлэгч иргэн)

Г.Тэмүүлэн (Туулант гол ХХК)

Б.Хүрэлхүү (Төрийн банкны теллер)

Г.Дэжидсүрэн (ЗДТГ-ын нягтлан бодогч)

Б.Сармандах (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Б.Баттогтох (Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ч.Баярмаа (Санхүү, төрийн сангийн албаны дарга)

2.Аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан хэрэгжүүлж, татвар төлөгчдийн өдрүүдэд зохион байгуулагдах спортын арга хэмжээнд баг, тамирчдыг бэлтгэн амжилттай оролцуулан ажиллахыг ажлын хэсэг (Д.Ганчимэг)-т даалгасугай.

3.Тус аяны хүрээнд зохион байгуулагдаж буй спортын арга хэмжээнд хэрэглэгдэх шатахууны зардлыг сумын Засаг даргын нөөц сангаас албаны дарга (Ч.Баярмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

М.БАЯРСҮХ